

# ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2020



Малчдын гомдол барагдуулах  
гэрээний хэрэгжилт (2017-2020)



2014 оны 5-р сард  
IEP at OT mine site, May, 2014



ИМТ Хамтран Олж Тогтоох шинжээчид малчид  
ажиллаж байгаа нь, 2016 оны 5-р сар  
Fact Finding Experts are gathering information  
from herders, May 2016



May, 2016



Освальдо Гратакос, дэд ерөнхийлөгч  
эвлэрүүлэн зуучлах багийн хамт  
ОТ-н уурхайд, 2015 оны 6-р сар  
Oswaldo Gratacos, CAO Vice President & mediation team  
at OT mine site, June, 2015



IFC International Finance Corporation  
WORLD BANK GROUP  
CommDev  
Foros Se  
Los debates que el mundo necesita



Training for TPC





## Гурван Талт Зөвлөлийн Удирдах нэгжийн мэндчилгээ

### 1-Р БҮЛЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 1.1 Зөвлөлийн дарга, хурлууд
- 1.2. Гурван Талт Зөвлөлийн гишүүд
- 1.3. ГТЗ-ийн гишүүдийн ашиг сонирхлын зөрчлийг удирдах журам
- 1.4. Зөвлөх ажиллагаа
- 1.5. Хяналт үнэлгээ
- 1.6. Мэдээллийн ил тод байдал
- 1.7. Чадавхи бэхжүүлэх
- 1.8. Нарийн бичиг
- 1.9. Зөвлөлд ирсэн санал хүсэлт гомдлыг шийдвэрлэсэн байдал

### 2-Р БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

- 2.1. Хөөн хэлэлцэх нөхөн олговор
- 2.2. Мониторинг
  - 2.2.1 Байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлын явц
  - 2.2.2. Хамтын оролцоотой байгаль орчны мониторингийн хөтөлбөр
  - 2.2.3. Бэлчээрийн хяналт
  - 2.2.4. Хаягдал хадгалах байгууламжын мониторинг
- 2.3. Тогтвортой амьжиргааны төсөл хөтөлбөр
  - 2.3.1. Ундай голын өв соёл-2 төсөл
  - 2.3.2. Тогтвортой амьжиргааг дэмжих төсөл
  - 2.3.3. Оюутны сургалтын тэтгэлэгт хөтөлбөр
  - 2.3.4. Мал нядалгааны зам, малчны захын төсөл

### Хавсралт 1. Гэрээний хэрэгжилт 2017-2020

# Гурван Талт Зөвлөлийн Удирдах нэгжийн мэндчилгээ

Та бүхэндээ Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж байгаагаа баяртай байна.



**Х.ОТГОНЖАРГАЛ**

ГТЗ-ийн дарга, Ханбогд сумын засаг захиргааны төлөөллийн ахлах, Ханбогд сумын Засаг даргын орлогч



**С.НАМСРАЙ**

Ханбогд сумын Малчдын төлөөллийн ахлах, Жавхлант багийн малчин



**С.ДОРЖДЭРЭМ**

Оюу толгой ХХК-ийн талын төлөөллийн ахлах, Орон нутгийн харилцааны менежер

2020 онд Гурван талт зөвлөлийн талууд, гишүүд, малчид, хамтрагч байгууллагууд Малчдын гомдол барагдуулах хоёр гэрээний хэрэгжилтийг хангахын төлөө тууштай хамтран ажиллалаа. Ковид 19 цар тахлын шинэ нөхцөлд төлөвлөсөн ажлуудаа хэрэгжүүлэхэд ихээхэн бэрхшээлтэй тулгарсан хэдий ч Гэрээнд заасан олон ажлуудыг амжилттай урагшлуулаад байна.

2020 онд Гэрээгээр тохирсон ажлуудын хэрэгжилт 69% гүйцэтгэлтэй буюу бүх ажлуудын гуравны хоёр нь хэрэгжээд байна. Хамгийн сайн хэрэгжиж буй ажил болох өрхийн хөөн хэлэлцэх нөхөн олговрын ажил дуусах шатандаа ороод байгааг онцлон дурдах нь зүйтэй юм. Батлагдсан нэхэмжлэлийн дагуу 3.6 тэрбум төгрөгийг 157 малчинд олгоод байна. Өмнөх онуудад амжилттай хэрэгжсэн зарим төслүүдийг Зөвлөлөөрөө зөвшилцөн хэлэлцсэний үндсэн дээр үргэлжүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

2019-2020 онуудад Зөвлөлийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтын хувьд шинэ шатанд гаргах олон ажлуудыг санаачлан хэрэгжүүллээ. Зөвлөлийн үйл ажиллагаанд малчдын төлөөлөл, оролцоо, саналыг нэмэгдүүлэх үүднээс Малчдын төлөөллийн гишүүдийн

тоог нэмэгдүүллээ. Зөвлөлийн Дүрэмд заасны дагуу хариуцлагатай, ёс зүйтэй, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, нам улс төрөөс ангид байх зарчмыг баримталж ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс “ГТЗ-ийн гишүүдийн ашиг сонирхлын зөрчлийг удирдах журам” батлан хэрэгжүүлж эхэллээ. Мөн Зөвлөлийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангахын тулд Зөвлөлийн цахим хуудас нээх, нийгмийн сүлжээний хаяг нээн ажиллуулах зэргээр мэдэллийн сувгуудыг нээн ажиллуулж байна.

2021 онд бид Малчдын гомдол барагдуулах хоёр гэрээний хэрэгжилтийг сайжруулж, ёс зүйтэй, хариуцлагатай ажиллаж, бидний хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн үр шим цаашид илүү олон хүнд хүрэх болно гэдэгт итгэлтэй байна.

Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг бид хамтдаа бүтээн.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.

# 1-Р БҮЛЭГ | УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

## 1.1 Зөвлөлийн дарга, хурлууд



Гурван талт зөвлөлийн дүрэмд зааснаар Зөвлөлийн шийдвэрийг Зөвлөлийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэдэг. Зөвлөлийн хурлыг улирал бүр зохион байгуулж, Гэрээний хэрэгжилт болон бусад үйл ажиллагааны талаар хэлэлцэж шийдвэрлэхээр заасан байдаг. 2020 онд Ковид 19 цар тахлын халдвараас сэргийлэх нэгдсэн хорио хязгаарлалт бүхий шинэ хүндрэлтэй нөхцөлд Зөвлөлийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах, Гэрээний хэрэгжилтийг урагшлуулах үүднээс харилцаа холбоондоо зайны арга барилыг нэвтрүүлж ажиллалаа. 2020 оны 1, 4, 8, 10-р саруудад Зөвлөлийн бүх гишүүдийн 90%-ийн оролцоотойгоор хурлыг зохион байгуулж ажилласан. 8 боло 10 сарын хурлыг хагас онлайн байдлаар MS Teams ашиглан зохион байгууллаа.

Зөвлөлийн тэргүүнээр талуудын ахлах гишүүд жил бүрээр ээлжлэн ажиллахаар дүрэмд зохицуулсаны дагуу 2020

оны 6 сараас эхлэн Ханбогд сумын засаг захиргааны төлөөллийн ахлах Зөвлөлийн даргаар ажиллаж байна. Зөвлөлийн Удирдах нэгжийн хурал 8 сараас эхлэн хоёр долоо хоног тутамд тогтмол хийгдэж ирлээ.

2020 онд Зөвлөлийн хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үүднээс ажлын хэсгүүд буюу Зөвлөлийн мэдээллийн зорилтыг хэрэгжүүлэх болон гэрээний хэрэгжилтийг хангах зорилго бүхий дөрвөн ажлын хэсэг байгуулж ажилласан. Тухайлбал, ГТЗ-ийн цахим хуудас байгуулах, Малчдын зах, мах хядалгааны зам ажиллуулах, Бэлчээрийн усны хангамж сайжруулах, Малын тэжээлийн сан байгуулах ажлын хэсэг ажилласан. Малын тэжээлийн сан байгуулагсан тул ажлын хэсэг татан буугдсан ба бусад ажлын хэсэг үргэлжлүүлэн ажиллаж байна.

## 1.2. Гурван Талт Зөвлөлийн гишүүд

### ОНЗЗ

Х.Отгонжаргал Ханбогд сумын Засаг даргын орлогч  
Б.Алтангэрэл Ханбогд сумын Уул уурхай, байгаль орчин хариуцсан мэргэжилтэн  
Э.Жамбалсанжид Ханбогд сумын Жавхлант багийн Засаг дарга  
М.Мягмаржав Ханбогд сумын Баян багийн Засаг дарга  
Д.Эрдэнэцэцэг Ханбогд сумын Гавилууд багийн Засаг дарга

### МТ

Д.Намсрай Жавхлант багийн малчдын төлөөлөл  
Ө.Баттогтох Жавхлант багийн малчдын төлөөлөл

Ч.Намнансүрэн Жавхлант багийн малчдын төлөөлөл  
Р.Бадамдорж Баян багийн малчдын төлөөлөл  
Ц.Ганбаатар Баян багийн малчдын төлөөлөл  
Х.Нэхийт баян багийн малчдын төлөөлөл  
Ц.Олонбаяр Номгон багийн малчдын төлөөлөл  
Д.Эрхэмбаатар Номгон багийн малчдын төлөөлөл  
Д.Отгончулуу Гавилууд багийн малчдын төлөөлөл  
У.Гантөмөр Номгон багийн малчдын төлөөлөл  
Т.Насанбуян Гавилууд багийн малчдын

### ТӨЛӨӨЛӨЛ

М.Хашбаатар Гавилууд багийн малчдын төлөөлөл

### ОТ


С.Дорждэрэм Орон нутгийн дэмжлэг, түншлэлийн менежер  
Л.Баярбаатар Орон нутгийн харилцааны хэлтсийн мэргэжилтэн  
О.Дарьханд Хэвлэл мэдээллийн ерөнхий зөвлөх  
С.Отгонбаатар Усны менежментийн багийн ахлагч  
Ж.Эрдэнэбилэг Хөдөлмөрийн харилцааны менежер

2019 оны 7 сард шинэчлэн баталсан ГТЗ-ийн дүрэмд зааснаар ГТЗ-ийн гишүүдийн тоог 22 болгож нэмэгдүүлсэн. Энэ өөрчлөлт нь Зөвлөлийн үйл ажиллагаанд малчдын оролцоог дэмжих нэмэгдүүлэх үүднээс малчдын талын төлөөллийн тоо 12 болгосонтой холбоотой юм. Ингэснээр Ханбогд сумын засаг захиргаа болон Оюу толгой ХХК-ийн талын төлөөлөл тус бүр 5 төлөөлөлтэй хэвээрээ, малчдын талын төлөөллийн тоо 12 болоод байна.

Малчдын төлөөллийг сонгохдоо Ханбогд сумын дөрвөн багийн хурлаас сонгогдсон 2019 оны хурлаар шинээр 5 гишүүн сонгосон.

2020 оны орон нутгийн сонгуулийн үр дүнд мөн Ханбогд сумын засаг захиргааны төлөөлөлд өөрчлөлт гарсан. Ингэснээр Зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлүүд гарч, 3 шинэ гишүүн нэмэгдлээ.


### 1.3. ГТЗ-ийн гишүүдийн ашиг сонирхлын зөрчлийг удирдах журам



2021 оны 1 сарын 28ны өдрийн Гурван талт зөвлөлийн хурлаар Гурван талт зөвлөлийн үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчлийг удирдах журам-г хэлэлцэж баталлаа.


Энэ журам Гурван талт зөвлөлийн үйл ажиллагааг Ханбогд сумын нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх, ил тод байдлыг хангах, олон нийтийн итгэлийг даах нөхцлийг бүрдүүлэх үүднээс Зөвлөлийн үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, удирдах, хянахад зорилготой.

Журмын хүрээнд ашиг сонирхлын байдлыг мэдүүлэх, баталгаажуулах, хувийн ашиг сонирхлын зөрчлийг



удирдах, журам зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг зохицуулсан болно.


Журамд Гурван талт зөвлөлийн үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчлийг удирдах зарчим болон Ашиг сонирхлын зөрчлийг мэдэгдэх, тайлбарлах явыг тодорхой тусгасан ба Зөвлөлийн гишүүн хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ өөрөө үнэн зөв гаргах үүрэгтэй болохыг тусгасан байна. Зөвлөлөөс хэрэгжүүлү буй үйл ажиллагаанд гишүүдийн өмнө тавигдах хязгаарлалтууд, тухайбал, шийдвэр гаргах, сурталчилах, төлөөлөх эрхтэй холбоотой ашиг сонирхлыг зөрчлөөс сэргийлэх хязгаарлалтыг тусгасан байна.



Журмыг хэрэгжилтэнд хяналт тавих үүргийг Зөвлөлийн Дотоод хяналтын хороо гүйцэтгэх ба ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлэгт дүн шинжилгээ хийж, хяналт шалгалтын дүгнэлт гаргаж, Зөвлөлд тайлагнах үүрэг хүлээх юм.


Гурван талт зөвлөлийн үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж чадсанаар Зөвлөлийн үйл ажиллагаанд ил тод байдлыг хангаж, сум орон нутгийн иргэдийн итгэлийг хүлээж Зөвлөлийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

### 1.4. Зөвлөх ажиллагаа




ГТЗ-ийн дүрмийн хх-д заасны дагуу зөвлөх ажилладаг.

ГТЗ-ийн малчдын төлөөллийн зөвлөхөөр олон улсын байгууллага болох Хариуцлагатай байдлын зөвлөл (Accountability Council International NGO-AC) үргэлжүүлэн



ажиллаж байна. ОТ Хяналт ТББ нь 2020 оны 1 сараас эхлэн малчдын төлөөллийн талд зөвлөх үйлчилгээ үзүүлэхээ зогсоосон болно.


Ханбогд сумын Хөгжлийн шийдэл ТББ нь ГТЗ-ийн төсөл хөтөлбөрт зөвлөх үйлчилгээ үзүүлж байна.



Тухайлбал, Малчны зах, мал нядалгааны замыг байгуулах төслийг төлөвлөх, хэрэгжүүлэх, Малчны апп, Тогтворотой хөгжлийн төслүүдэд зөвлөхөөр ажиллаж байна.

## 1.5. Хяналт үнэлгээ

ГТЗ-ийн дүрэмд 7-д даасны дагуу Гэрээний хэрэгжилтэнд дотоод гадаад хяналт үнэлгээ хийж байна. Гэрээний хэрэгжилтэнд гурван шатны хяналтын ажиллагаа хийдэг. ГТЗ-ийн дотоод хяналт үнэлгээг хийж, ГТЗ-ийн хурлаар хэлэлцдэг. Малчдын төлөөллийн зөвлөлийн хяналт үнэлгээ жил тутам хийгдэж байна. Хараат бус хөдлөнгийн үнэлгээ хийхээр дүрэмд заасан.



### Дотоод хяналт

ГТЗ-ийн дотоод хяналт үнэлгээг 2020 оны 4, 8-р саруудад Зөвлөлийн хурлаар хийсэн. Гэрээний хэрэгжилтийг үнэлэх аргачлалаа тохирч, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн дагуу гэрээнд давхардаж орсон заалтуудыг хасаад нийтдээ 65 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тохирсон. Эдгээр үйл ажиллагааны хэрэгжилт 69%-ийн гүйцэтгэлтэй байна гэж Зөвлөлийн хурлаар үнэлсэн. Өрхийн хөөн хэлэлцэх нөхөн олговор олгох ажиллагааны хэрэгжилт хамгийн өндөр гүйцэтгэлтэй буюу 97%, нийтийн нөхөн олговрын хүрээнд тохирсон ажлыг хэрэгжилт хамгийн доогуур буюу 26%-ийн гүйцэтгэлтэй байна. Хавсралт 1-д гэрээний хэрэгжилтийн үнэлгээг хүснэгтээр үзүүлээ.

### Малчдын зөвлөхийн үнэлгээ

Малчдын зөвлөхийн жилийн үнэлгээ 2020 оны 5 сард хийгдсэн. Үнэлгээний тайланг энэ холбоосоор үзэх боломжтой. <https://www.tpcprogress.com/>.

### Хөндлөнгийн үнэлгээ

Хараат бус хөндлөнгийн үнэлгээ 2021 онд хэрэгжүүлнэ.

## 1.6. Мэдээллийн ил тод байдал

ГТЗ-ийн дүрэмд Зөвлөлийн үйл ажиллагааны ил тод байдал, мэдээллийг сайжруулах талаар зохицуулсан байдаг. 2020 онд мэдээллийг шуурхай хүргэх, холбоо харилцааг сайжруулах чиглэлээр идэвхтэй ажиллаа. Цахим холбоо харилцааны сувгуудыг нээн ажиллаж, өдөр тутмын харилцаандаа

нэвтрүүлээд байна.

ГТЗ-ийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг сум орон нутгийн иргэдэд шуурхай хүргэх, гадаад тодоодын оролцогч талуудад нээлттэй мэдээлэхийн тулд ГТЗ-ийн цахим хуудсыг нээхээр ажиллаж байна. <https://invis.io/6VYPOTT7YNJ>; ГТЗ-ийн Фейсбүүк хуудсыг нээгээд

байна. Ямар ямар мэдээллийг энүүгээр тарааж байгаа болох (<https://www.facebook.com/TripartiteCouncilB>)

Мөн ГТЗ-ийн емейл хаягтай боллоо. ([tripartitecouncil.kb@gmail.com](mailto:tripartitecouncil.kb@gmail.com)) Зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцан ажиллаж байна.

## 1.7. Чадавхи бэхжүүлэх



ГТЗ-ийн дургийн дагуу Зөвлөлийн гишүүд өөрчлөгдөх, шинээр томилогдох явцыг дүрэмдээ зохицуулсан байдаг. Нээлттэй ажиллагаатай бүтэц юм. 2020 онд 8 шинэ гишүүнтэй боллоо. Зөвлөлийн шинэ гишүүдэд Зөвлөлийн үйл ажиллагааны тухай танилцуулах, үйл ажиллагааны

онцлог баримтлах зарчим, арга барилыг танилцуулах сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Мөн цар тахлын нөхцөл байдалд онлайн хурал уулзалт зохион байгуулахад шаардлагатай мэдээлэл дадал олгох сургалтыг нийт гишүүдийг хамруулан хийлээ.

## 1.8. Нарийн бичиг


ГТЗ-ийн дурамд зааснаар Зөвлөлийн нарийн бичиг хараат бус байна. Энэ шаардлагыг хангах үүднээс Зөвлөлийн нарийн бичгийн ажилтныг сонгон шалгаруулалт явагдаж байна.



### 1.9 Зөвлөлд ирсэн санал хүсэлт гомдлыг шийдвэрлэсэн байдал




2020 онд ГТЗ-д нийт 13 гомдол санал ирсэн ба эдгээрийн 4-т буюу 30%-д нь зохих хариуг өгсөн. 9 гомдлыг судлах, хэлэлцэх ажил хийгдэж байна. Нийт гомдол саналын тал нь нөхөн олговортой холбоотой байна.



## 2-Р БҮЛЭГ | ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ



Ханбогд сумын Гурван талт зөвлөлд оролцогч талууд болох Ханбогд сумын засаг захиргаа, Ханбогд сумын малчид, “Оюу толгой” компани хамтран 2017 оны 5 дугаар сарын 9-нд Малчдын гомдол барагдуулах хоёр гэрээг байгуулсан. Малчдын гомдол барагдуулах хоёр гэрээнд малчдын гомдлыг барагдуулахын тулд хийх ажлууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, хариуцах талыг тодорхойлон үйл ажиллагааны төлөвлөгөөний хамт нэг бүрчлэн хэлэлцэн тохирсон болно. Эдгээр Гэрээ нь олон нийтэд нээлттэй бөгөөд бүрэн эхээр нь Орон нутгийн сонины 2017 оны тусгай дугаарт хэвлэн Ханбогд сумын иргэд, олон нийт, малчин айл өрхүүдэд түгээсэн болно. Энэхүү хоёр Гэрээнд бэлчээр ус, нөхөн олговор, Ундайн голын асуудлаар нийтдээ 60 гаруй асуудлыг шийдэхээр тусгасан. Малчдын гомдол барагдуулах хоёр гэрээний хэрэгжилтийг хангахын төлөө Зөвлөл тууштай хамтран ажиллаж байна. 2020 онд Зөвлөлийн хурлаар Гэрээгээр тохирсон ажлууд 69% гүйцэтгэлтэй гэж 2020 оны 8 сарын байдлаар үнэлсэн.




2020 онд цар тахлын шинэ нөхцөл дунд харилцаа холбоо талаасаа ихээхэн бэрхшээлтэй тулгарсан хэдий ч Гэрээнд заасан олон ажлуудыг амжилттай урагшлуулж чадлаа. Өрхий хөөн хэлэлцэх нөхөн олговрын ажлыг амжилттай хэрэгжүүлж, батлагдсан нэхэмжлэлийн дагуу нөхөн олговор олгох ажиллагаа дуусах шатандаа байна. Зарим дууссан төслүүдийг үргэлжүүлэн хэрэгжүүлж байна. Тухайлбал, Ундай голын соёлын өвийг төсөл болон малчны худаг засах ажлыг үргэлжлүүлсэн. Мөн шинээр Хаягдлын далангийн хамтын оролцоотой мониторингийг санаачлан эхлүүлж, Хамтын оролцоотой байгаль орчны мониторингийн хөтөлбөрийн хүрээнд Мөнх ноон Галба ТББ-тай хамтран хэрэгжүүлж байна.

Энэ бүлэгт 202 онд хэрэгжсэн зарим ажлуудын явцыг танилцуулж байна. Гэрээнд тохирсон бүх арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг Хавсралт 1-д үзүүлсэн нэгдсэн хүснэгтээс үзнэ үү.


## 2.1. Хөөн хэлэлцэх нөхөн олговор

- Гэрээний холбогдох заалт: Малчдын гомдлыг барагдуулах гэрээ №1-ийн Хавсралт 1-ийн 4.1-оос 4.9
- Хэрэгжүүлэгч: Нөхөн олговрын нэхэмжлэлийн хороо
- Хэрэгжсэн хугацаа: 2017 оны 6 дугаар сараас 2020 оны 12 сар
- Гүйцэтгэлийн хувь: 97%
- Зарцуулсан мөнгөн дүн: 1.8 ам доллар

Зураг 2. Хөөн хэлэлцэх нөхөн олговорт хамрагдсан өрхийн тоо, багаар



Зураг 3. Хөөн хэлэлцэх нөхөн олговорт хамрагдсан өрхийн тоо, төрлөөр



Гэрээнд Нөхөн олговрын нэхэмжлэлийн хороо ажиллуулах 2004, 2011оны нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын хөтөлбөрт хөөн хэлэлцүүлэхээр ирүүлсэн малчин өрхийн нэхэмжлэлийг шийдвэрлэх арга хэмжээний талаар тохирсон. Гурван талт зөвлөл нь Гэрээнд тохирсон ажлыг хэрэгжүүлэхийн тулд 2004, 2011 оны нөхөн олговрын хөтөлбөрийн дагуу малчид нэхэмжлэл нөхөн олговор авах шалгуурыг хангасан эсэхийг шийдвэрлэх үүрэг бүхий Нөхөн олговрын нэхэмжлэлийн хорооны (Нэхэмжлэлийн хороо) үүргийг 2017 оны 6 сараас 2019 оны 03 сар хүртэлх хугацаанд гүйцэтгэж ажилласан. Хороо нь Зөвлөлөөс хамтран боловсруулж баталсан Нөхөн олговрын нэхэмжлэлийн хорооны журмыг даган мөрдөж ажилласан бөгөөд уг журмын 4-т заасан шалгуурт хамаарч нөхөн олговор авахаар нэхэмжлэл гаргасан нийт 235 малчин өрхийн нэхэмжлэлийг 2017 оны 06 дугаар сараас 2019 оны 01 дүгээр сарын 15-ны

хооронд буюу нэг жил 06 сарын хугацаанд хүлээн авсан. Хороо нь нийт 235 нэхэмжлэлээс нөхөн олговор авах шалгуур хангасан 160 өрхийн нэхэмжлэлд нөхөн олговор олгохоор тохирсон ба энэ нь Ханбогд сумын нийт 384 малчин өрхийн 40 хувьтай тэнцэж байна. Эдгээр өрхтэй “Оюу толгой” компаниас нийт 3.6 тэрбум гаруй төгрөгийн дүн бүхий нөхөн олговрын гэрээ байгуулан дэмжлэгийг олгосон. 75 нэхэмжлэл шалгуур хангаагүй учраас нөхөн олговор олгохоос татгалзсан шийдвэр гаргаж нэхэмжлэл гаргагчид албан ёсны хариуг өгсөн.

Хорооны журмын дагуу сүүлийн нэхэмжлэл хүлээн авсан өдрөөс хойш 3 сарын дараа буюу 2019 оны 03 дугаар сард Нөхөн олговрын нэхэмжлэлийн хороог “үүргээ гүйцэтгэсэн” гэх үндэслэлээр татан буулгасан. Цаашид Гурван талт зөвлөл нь Нэхэмжлэлийн хорооны шийдвэрийг хэрэгжүүлэх, хянах, гүйцэтгэлийг хангаж ажиллаж байна.



## 2.2.2. Хамтын оролцоотой байгаль орчны мониторингийн хөтөлбөр

- Гэрээний холбогдох заалт: Малчдын гомдлыг барагдуулах гэрээ №1-ийн Хавсралт 1-ийн 3.1
- Төсөл хэрэгжүүлэгч: “Мөнх ногоон галба” ТББ
- Жилийн төсөв: 240 сая төгрөг
- Төсөл хэрэгжиж буй газар: Ханбогд сум
- Хэрэгжилтийн хувь: 80%



“Оюу толгой” ХХК-ийн Орон нутгийн харилцааны хэлтэс, Байгаль орчны хэлтэс хамтран 2011 оноос эхлэн Нутгийн иргэдийн оролцоотой байгаль орчны мониторингийн хөтөлбөрийг хэрэгжүүлж ирсэн. Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн гаргасан шийдвэр, Малчдын гомдлыг барагдуулах гэрээний 3.1 дэх заалтын дагуу хэрэгжүүлэхээр тохирсон нэг ажил нь нутгийн иргэдийн оролцоотой байгаль орчны мониторингийн ажлыг шинэчлэн сайжруулах, ингэхдээ оролцогч иргэд малчдыг мэргэжлийн түвшинд мониторинг хийх хэмжээнд чадавхжуулах, малчид чин сэтгэлээсээ оролцож хариуцлагатай хандах хөшүүрэг бий болгохын тулд оролцогч нарыг цалин урамшуулалтай болгох, мониторингийн арга зүйн хувьд мал маллагааны хэв маягт зохицуулсан, шинжлэх ухааны үндэслэлтэй, талуудын итгэл үнэмшлийг хангасан байхаар шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх явдал байсан.

Иймээс нутгийн иргэдийн оролцоотой байгаль орчны мониторингийн хөтөлбөрийг орон нутгийн байгууллага буюу Ханбогд сумын иргэд, малчид сайн дураар эвлэлдэн нэгдэж байгуулсан “Мөнх ногоон Галба” ТББ хэрэгжүүлж байна. “Мөнх ногоон Галба” ТББ нь Удирдах зөвлөлийн 7 гишүүн, Хяналтын зөвлөлийн 5 гишүүнтэй. Гүйцэтгэх захиргаа буюу байнгын ажлын байранд захирал, нягтлан бодогч, захиргааны мэргэжилтэн болон байгаль орчны 3 мэргэжилтэн, нийт 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2018 оны 8 дугаар дугаар сарын 1-нээс албан ёсоор үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

2020 оны тэргүүлэх чиглэл нь Ус, бэлчээр, агаарын чанар, амьтан, ховор мод, бэлчээр ургамлын хяналт, олон нийтийн байгаль орчны мэдлэгийг дээшлүүлэх, эрдэмтэн доктор профессоруудаас зөвлөгөө, мэдлэг мэдээллийг үргэлжлүүлэн авч чадавхижсаар байна.

Хяналтын үр дүнг орон нутгийн сонин, сошиал медиа ашиглан олон нийтэд мэдээлэх Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх ТББ-уудыг үргэлжлүүлэн ажиллуулах хүрээнд 2020–2022 онуудад хоёр жилийн хугацаанд чадавхи бэхжүүлэх төлөвлөгөө боловсруулан үр дүнтэй ажиллаж байна.


ОТ байгаль орчны хэлтэс ба гэрээт гүйцэтгэгчид болох ТББ-ын хамтын ажиллагааг үргэлжлүүлж Хаягдал хадгалах байгууламжийн хяналт шинжилгээний төлөвлөгөөг Гурван талт зөвлөлийн гишүүдтэй хамтран гаргасан. Нутгийн иргэдийн оролцоотой байгаль орчны мониторингийн хөтөлбөрийн хэрэгжилт, “Мөнх ногоон Галба” ТББ -ийн үйл ажиллагааны мэдээллийг ... холбоосоор авах боломжтой.

## УСНЫ ХЯНАЛТ



Усны хяналт шинжилгээнд 85 малчин оролцож байна. Малчны худгийн усны тоолуурын хяналтын үр дүнг доор харуулав, усны түвшний өөрчлөлт 0,02-0,40 м байна. Усны түвшний хяналтыг сард 10 удаа хийдэг.

| Багийн нэр      | Оролцогч малчид | Усны түвшний өөрчлөлт |
|-----------------|-----------------|-----------------------|
| <b>Баян</b>     | 16              | 0,02-0,40 м           |
| <b>Номгон</b>   | 18              | 0,02-0,30 м           |
| <b>Гавилууд</b> | 20              | 0,02-0,30 м           |
| <b>Жавхлант</b> | 31              | 0,03-0,25 м           |




27 гүний худгийн усны түвшний хяналтыг улирал тутам хийдэг. Усны түвшний өөрчлөлт 0,05-0,30 м байна. Өвлийн улиралд усны түвшний өөрчлөлт 0,05-0,10 м байна. 3,4-р улиралд усны түвшин нэмэгдэж байна.

Усны чанарын хяналт (Хүчил, шүлтийн тун - PH) -Ундны 10 худгийн дээжийг шалгуур үзүүлэлтээр шинжилсэн бөгөөд үр дүн нь Монгол Улсын MNS 900: 2010 стандартыг хангасан болно.

## ТООСЖИЛТЫН ХЯНАЛТ

Тоосжилтын хяналтыг Оюу Толгойн (Dust truck) тоос хэмжигч багажыг ашиглан 5 цэгт 2020 оны 5-р сараас эхэлсэн. Хяналтыг улирал тутам явуулдаг.




## ХАЙЛААС МОДНЫ ХЯНАЛТ




Эхний удаа бид олон нийтийн оролцоотой мониторинг хийх замаар Ханбогдын нутаг дэвсгэр дэх бүх хайлаас модыг тоолохоор төлөвлөж байсан. 2020 оны байдлаар бид хамгийн их хайлаас модтой нутаг буюу Жавхлант багийн 9631 ширхэг хайлаас модыг тооллоо. Тоологдсон хайлаас бүрийн диаметр, өндөр, малчин авсан фото зураг, тоолсон Хайлаас модны координатыг бүртгэж авлаа.

| Сэдэв                             | 2019        | 2020        | Нийт        |
|-----------------------------------|-------------|-------------|-------------|
| <b>Нийт тоолсон мод</b>           | <b>3464</b> | <b>6167</b> | <b>9631</b> |
| <b>Унасан ба өгөршсөн хайлаас</b> | <b>320</b>  | <b>327</b>  | <b>647</b>  |




## АМЬТНЫ АЙМГИЙН ХЯНАЛТ



Зургадугаар сараас эхэлсэн ан амьтны хяналт шинжилгээнд 16 малчин оролцож байна.


Ханбогд сумын нутаг нь 16 бүсэд хуваагддаг бөгөөд 1 малчин 100 км радиустай бүсэд хяналт шинжилгээ хийдэг ба судалгаа нь Ханбогдын нутаг дэвсгэрийн 30 хувийг хамардаг. Малчдын авсан гэрэл зургуудыг Фэйсбүүк болон Орон нутгийн сонинд нийтлэгддэг.

### Тоологдсон зэрлэг ан, амьтдын тоо



### Зэрлэг амьтан ажиглалтын замнал

Write a description for your map.



2019 онд малчдын 68 гар худагт усны түвшин хэмжилт, 10 уст цэгт ундны усны чанарын шинжилгээ, 8 цэгт бэлчээрийн мониторинг, 16 цэгт зэрлэг амьтны ажиглалт мониторинг, нэг цэгт хайлаасны тооллого мониторинг хийж мониторингийн үр дүнг жилийн эцэст малчид иргэдэд танилцуулсан. Нийддээ 2019 онд 98 иргэд малчид мониторингийн ажилд мэдээлэл цуглуулж оролцоод байна. 2020 онд 113 иргэд малчид мониторингийн ажилд оролцож мэдээлэл цуглуулсан. Мөн Монголын эрдэмтэн судлаачидтай хамтран ажиллаж мэргэжлийн зөвлөгөө сургалт авч ажиллаж байна. Усны мониторингийн чиглэлээр Монгол улсын гавьяат багш, ШУТИС-ийн хүндэт профессор, Газар зүйн ухааны доктор Геологи-минералогийн шинжлэх ухааны доктор, профессор, Монгол улсын зөвлөх инженер Найдангийн Батсүхтэй хамтран ажиллаж байна.

Бид хурал уулзалт, нээлттэй өдөрлөг, багийн хуралд оролцож мэдээлэл хуваалцахаас гадна сонин сэтгүүл, олон нийтийн сүлжээ ашиглан мониторингийн мэдээллээ олон нийтэд хүргэн ажиллаж байна. 2021 оноос цар тахлаас шалтгаалаад интернет цахим сүлжээ ашиглан олон нийтэд мэдээлэл хүргэж байна.

Түүнчлэн нутгийн иргэдийн оролцоотой байгаль орчны мониторингийн хамрах хүрээг өргөтгөж дараах чиглэлийг хамруулах боллоо. Үүнд:


- Усны нөөц, хур тунадас,
- Хөрсний эвдрэл доройтол, хөрсний чийг,
- Бэлчээр ба ашигт ургамлууд,
- Зэрлэг ан амьтад ба байгалийн задгай уст цэгүүдийн ашиглалт,
- Агаарын чанар, орчны тоосжилт,
- Уул уурхайн нөлөөнд өртөж болзошгүй газруудад мониторингийн цогц үйл ажиллагаа,
- Залуу үе, сургуулийн сурагчдад чиглэсэн экологийн боловсролыг дээшлүүлэх ажил зэрэг болно.



### 2.2.3. Бэлчээрийн хяналт

- Гэрээний холбогдох заалт: Малчдын гомдлыг барагдуулах гэрээ №1-ийн Хавсралт 1-ийн 3.1
- Төсөл хэрэгжүүлэгч: “Мөнх ногоон галба” ТББ
- Жилийн төсөв: 240 сая төгрөг
- Төсөл хэрэгжиж буй газар: Ханбогд сум

Бэлчээрийн төлөв байдлийн ажиглалтыг 18 цэгт явуулдаг бөгөөд ургамалын суурь хоорондын зай, олон наст ургамал хоорондын зай, ургамалаас дээж авах, фото зураг авах зэрэг 8 малчинтай хамтран ажиллахын зэрэгцээ Нутгийн захиргаа, Цаг уурын станц, Оюутолгой ХХК хамтран уялдаа холбоотой ажиллаж байна.



### 2.2.4. Хаягдал хадгалах байгууламжын мониторинг

Мониторингийн үндэслэл: Хаягдлын сангийн уснаас нэвчилт болон далан сэтрэх ослоос химийн бодис агуулсан бохир ус алдагдаж орчны хөрс, хөрсний ус, ургамал, амьтанд нөлөөлж болзошгүй эрсдэлтэй байна. Иймээс Хаягдал хадгалах байгууламжийн бүсэд учирч буй байгаль орчны нөлөөллийг судлах санал зөвлөмжийг ГТЗ-өөс гарсан.

Мониторингийн зорилго: ХС нь ойролцоох болон урсгалын доош байрлах цооног, малчдын худаг булаг зэрэг уст цэгүүдүүд, хөрс, ургамал, амьтанд нөлөөлөх нөлөөллийг “Мөнх ногоон галба” ТББ малчидын оролцоотой тодорхойлоход оршино.

Тиймээс дараахь арга зүйгээр төлөвлөгөө гаргасан

1. 10 км-т нутаглаж байгаа малчдын энгийн гар худгуудын ундны усны дээжийг шинжилгээг Монгол улсын холбогдох стандарт буюу унд ахуйн усны чанарын шинжилгээ хийх арга зүйн дагуу буюу усны дээж авах, тээвэрлэх, шинжилгээнд хамруулах үзүүлэлт зэргийг хийхэд Монгол улсын стандартад заасан шаардлагыг баримтан шинжилж дээжийг Монгол улсын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд илгээнэ. Гарсан хариуг худаг эзэмшигч нарт гардуулна.
2. Задгай уст цэгийн усны шинжилгээ /Бохир усны шинжилгээ өгөх/-лабораторын түвшинд ингэж ангилна. Монгол улсын холбогдох стандарт буюу унд ахуйн усны чанарын шинжилгээ хийх аргагүйн дагуу буюу усны дээж авах, тээвэрлэх, шинжилгээнд хамруулах үзүүлэлт зэргийг хийхэд МУ-ын стандартад заасан шаардлагыг баримтална. Дээжийг МУ-ын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд илгээж гарсан хариуг худаг эзэмшигч нарт гардуулна.
3. Шүүрлийн уснаас дээж авч бичил амь судлалын бактерлоги болон хүнд металлыг шинжлэх Монгол улсын холбогдох стандарт буюу унд ахуйн усны чанарын шинжилгээ хийх аргагүйн дагуу буюу усны дээж авах, тээвэрлэх, шинжилгээнд хамруулах үзүүлэлт зэргийг хийхэд МУ-ын стандартад заасан шаардлагыг баримтална. Дээжийг МУ-ын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд илгээж гарсан хариуг худаг эзэмшигч нарт гардуулна.
4. Хөрсний дээжийг далангийн гадна талаас авч шинжилгээнд өгөх Далангийн ойролцоо нэг цэгийг сонгож 15-20 см-н дээж авах Хөрсний дээж авахад бэлтгэж багаж тоног төхөөрөмжөө ариутгана.
5. Амьтны мониторингыг хаягдлын далан орчмоор дайран өнгөрөх, идээшин зусаж байгаа болон суурин шувуудын
6. Зүйлийн бүрдэл, тоо толгойг тогтоох
7. Ундаалж байгаа эсэх
8. ойролцоох үхсэн шувуудын сэг зэмийн бүртгэл / шалтгаан нөхцлийг тогтоох / хийх
9. Малын эрүүл мэндийн төвөөс зохион байгуулах малын суурь өвчний судалгаанд хаягдлын далангийн ойролцоох малчдын малыг хамруулж МЭМТ-тэй тохиролцож малчдаа зохион байгуулах хамруулах.
10. Хаягдлын далангийн эргэн тойронд “Нүдэн үзлэг” хийх ба шаардлагатай хэсгүүдэд далангийн багийн мэргэжилтэнгүүдтэй хамтран үзлэг хийх
11. Ургамлын мониторинг

## 2.3. Тогтвортой амьжиргааны төсөл хөтөлбөр

### 2.3.1. Ундай голын өв соёл-2 төсөл

- Гэрээний холбогдох заалт: Малчдын гомдлыг барагдуулах гэрээ №2-ийн Хавсралт 1-ийн 13.2
- Төсөл хэрэгжүүлэгч: Ханбогд сумын Ахмадын хороо
- Хамрагдсан малчдын тоо: 38
- Төсөл хэрэгжих газар: Өмнөговь аймаг Ханбогд сум
- Төсөл хэрэгжих хугацаа: 2019 оны 06 дүгээр сар – 2021 оны 10 дүгээр сар.
- Нийт төсөв: 85.5 сая төгрөг
- Гүйцэтгэлийн хувь: 67%



Д.Авир. шагай



Д.Хархүү. сур элдэх



Г.Шоовдор. дээл

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхлант багийн нутаг Ундайн гол дагуух өрхүүдийн ахмад настнуудад “Уламжлалт мал аж ахуйн өв, мэдлэгээ залуучуудад таниулан түгээх, зөвлөх, уламжлуулах сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд” нь зориулж урамшуулал олгох зорилго бүхий төслийг 2019 оны 6 дүгээр сараас Ханбогд сумын Ахмадын хороотой хамтран хэрэгжүүлж эхэлсэн билээ. Тус төслийн хүрээнд 2019 оны 6-12 сарын хооронд Жавхлант багийн нутагт амьдарч буй 38 ахмадууд уламжлалт мал аж ахуйн өв, мэдлэгээ залуучуудад таниулан түгээх, зөвлөх, уламжлуулах хх сургалт хийсэн. Төсөл үргэлжилсэн долоон сарын хугацаанд эдгээр сургалтад давхардсан тоогоор 2236 хүүхэд залуучуудад хамрагдсан байна.

ГТЗ-ийн саналаар хх учраас уг төслийг 2020 онд дахин үргэлжүүлэхээр шийдвэрлэсэн юм. 2020 оны 10-12 сарын хооронд Жавхлант багийн нутагт амьдарч буй 38 ахмад настан, мөн Ханбогд сумын 80 дээш настан 22, зорилтод бүлгийн 3 ахмад настан гэсэн нийт 63 ахмадууд сар бүр сонгосон сэдвээрээ 10-аас доошгүй хүүхэд залууст сургалт явууллаа. Яг ямар сэдэвтэй сургалт хийсэн гэдгийг оруулах

Оролцож буй ахмадууд бүртгэлийн тусгай хуудасаа Ахмадын хороонд өгснөөр сар бүр 100,000 төгрөгийн урамшууллаа авч байсан билээ. 2021 оны 1 сард 307 залуус сургалтанд хамрагдлаа. Ундайн голын өв соёлын 2021 оны 10 сар хүртэл хэрэгжихээр төлөвлөгдөж санхүүжилт нь шийдэгдсэн байна. Ундайн голын өв соёл төсөлд хамрагдаж байгаа ахмадууд төслийнхөө зорилго үйл ажиллагааг сайтар ойлгож үр хүүхэд ач зээ, гол усныхандаа өөрийнхөө мэддэг чаддаг бүхнээ заан сургаж өвлүүлэхээр чармайн ажиллаж байна. Төслийн үйл ажиллагааг танилцуулах, таниулах зорилгоор Оюутолгой сонин болон нийгмийн сүлжээ ажиглаж төслийн талаар мэдээлэл болон төсөлд оролцогч ахмад настангуудаас цуварлаар яриа бэлтгэж олон нийтэд сар бүр хүргэж байна.

Төсөл хэрэгжүүлэгч ахмадын мэдээлэл

| Ахмад нэрс      | Үйл ажиллагаа  |
|-----------------|--|
| 1. Ч.Амгалан    | Төслийн удирдах, Үйл ажиллагааны тайланг нэгтгэж мэдээлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах |
| 2. Б.Туяа       | Санхүүгийн тайлан хийх   |
| 3. Д.Баяраа     | Сургагч ахмадуудаас тайлан мэдээллийг цуглуулах  |
| 4. Д.Цэрэнхүү   |  |
| 5. Д.Цэцэгсүрэн |  |

## 2.3.2. Тогтвортой амьжиргааг дэмжих төсөл – ОТ


- Гэрээний холбогдох заалт: Малчдын гомдлыг барагдуулах Гэрээ №1-ийн Хавсралт 1-ийн 4.5.1-4.9
- Хэрэгжүүлэгч:
- Хамрагдсан малчдын тоо: 49
- Зардал: 411,6
- Төсөл хэрэгжих газар: Өмнөговь аймаг Ханбогд сум
- Төсөл хэрэгжих хугацаа: 2019 оны 06 дүгээр сар – 2021 оны 10 дүгээр сар.

2017 онд Тогтвортой амьжиргааг дэмжих сургалтын хөтөлбөрт 92 малчин хамрагдсан. Малчид сайн дураараа нэгдэж дараах 5 чиглэлээр төслөө боловсруулж хэрэгжүүлсэн. Компаниас төслүүдэд бизнесийн үйл ажиллагаагаа эхлүүлэх санхүүжилт олгосон. Улмаар төсөл хэрэгжүүлэгч малчид хуулийн этгээд байгуулах сургалтад хамрагдаж компани, хоршоо, бүлгийн зохион байгуулалтад орж тоног төхөөрөмжөө авч үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. Төслүүдийн тогтвортой хэрэгжилтийг хангахад мэргэжлийн туслалцаа үзүүлэх зорилгоор “Хөгжлийн шийдэл” ТББ гэрээгээр хамтран ажиллаж, сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгч байна. Төсөлд 2020.10 сарын байдлаар нийтдээ 49 өрх хамрагдаж байна.

- Газар тариалангийн төсөл
- Махны чиглэлийн Ангус үхэр үржүүлэх төсөл
- Оёдлын төсөл
- Тахианы аж ахуйн төсөл
- “Гавилууд шилмэл сүрэг” хонины төсөл


### ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ТӨСӨЛ:

9 малчин өрх нэгдэж “Энергийн ундарга” хоршоог байгуулсан. 2га ил талбай болон 6\*20 хэмжээтэй 5 хүлэмжинд хүнсний ногоо тариалж Оюу Толгой ХХК болон орон нутагтаа ханган нийлүүлж байна. Ихэвчлэн говийн хөрсөнд сайн ургадаг тарвас, хүлэмжинд өргөст хэмх, улаан лоолийг голчлон тариалж байна.



### ОЁДЛЫН ТӨСӨЛ:

Оёдлын компани нь 12 хувьцаа эзэмшигчтэй, 2018 оноос жилд нэг удаа хувьцаа эзэмшигч нарт ногдол ашиг өгч байгаа. ОТ-н худалдан авалтын хэлтсийг урьж 2 удаа үйлдвэрийн нөхцөл байдал, хүний нөөц, материалын нөөцөө танилцуулсан ба бүтээгдэхүүнийг сайжруулах, чанар стандарт ямар байх талаар мэдээлэл өгсөн. 5 жилийн стратеги, компаний бодлого журмаа сайжруулж хөгжүүлсэн.



- Логоны машин ажиллуулах сургалт -1
- 5s сургалт – 6 тус бүр хамруулсан.

## МАХНЫ ЧИГЛЭЛИЙН АНГУС ҮХЭР ҮРЖҮҮЛЭХ ТӨСӨЛ:



Үнээгийн говь хоршоо 14 гишүүнтэйгээр үйл ажиллагаа зохион байгуулж байна. 2020 оны 10 сарын байдлаар АНГУС үүлдрийн 9 бухтай. 2019онд мал угаалгын Ванн барьж ашиглалтанд оруулж тэр жилдээ 5000 орчим мал угаасан 2020онд ойр орчмын малчдын 5000орчим малыг угаасан.

2020 онд Ангус бухаар нийт 100орчим үхэр хээлтүүлэгт орсон. Ангус бухыг яаж нутагшуулан маллах талаар хоршооны гишүүд мэргэжилтэй болсон. Хоршоо жил бүр үхэртээ туулгалт хийх, угаах ажлыг уламжлал болгон зохион байгуулдаг.

## ТАХИАНЫ ТӨСӨЛ:



Тахианы төсөл нь Амжиргааг дэмжих сургалтад хамрагдсан 2 малчин өрхийн эмэгтэйчүүд нийлж "Галбын тахиа" нөхөрлөлийг байгуулан 2018 оноос хойш үйл ажиллагаа явуулж байна. Тус төслийн хүрээнд төслийн үйл ажиллагааг сайжруулах 5 жилийн төлөвлөгөө гаргаж,

тахиа байраа стандарт нийсэн болгох, тахианы тоо толгой нэмэгдүүлэх, ажлуудыг хийж гүйцэтгсэн байна. Мөн одоо байгаа тахианы өндөгөөр бүтээгдэхүүн хийж өрхийн хэрэгцээгээ хангаж байна.

- Тахианы байранд шаардлагатай материалыг Оюу толгойн хог хаягдлын цэгээс авсан
- Тахианы байр, тахиануудаа ариутгал халдваргүйжүүлэлт хийлгүүлсэн.
- Шинээр 15 нутгийн бор тахиа худалдаж авсан.
- Тахианы насжилт болон өндөглөгч тахиаг ялгах талаар сургалт авсан.
- Даланзадгад хот тахиа болон аж ахуй эрхлэгч нартай уулзаж туршлага судалсан.

## МАХНЫ ЧИГЛЭЛИЙН ГАВИЛУУД ХОНИНЫ АЖ АХУЙ ЭРХЛЭХ ТӨСӨЛ.



- Гавилууд хэвшлийн хонь дундажаар 5.3-7.8%-иар илүү жинтэй, улсын хэмжээнд 4-рт орох үзүүлэлттэй.
- Ханбогд суманд ойролцоогоор 20000 толгой байгаа бөгөөд 40000 хүрч үүлдэрээр бүртгэгдэх сумын бодлоготой.
- 2019 онд 13 өрхийн хүрээнд “Гавилууд шилмэл сүрэг” хоршоо байгуулаад байгуулсан.
- Хоршоонд бүртгэлтэй 13 өрхөд 2 удаагийн худалдан авалтаар 455 толгой хонийг төслийн шугамаар байршуулсан.
- Эхний ээлжийн худалдан авалтын 260 хониноос 174 төл хүлээж аваад байна. Сумын ЗДТГ-тай гэрээ байгуулан хуцны суурь үүсгэх ажлыг зохион байгуулж эхэлсэн.

### 2.3.3. ОЮУТНЫ СУРГАЛТЫН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

- Гэрээний холбогдох заалт: Малчдын гомдлыг барагдуулах гэрээ №1 Хавсралт 1-ийн 4.10.2
- Хэрэгжүүлэгч: Гурван талт зөвлөл, “Ханбогд хөгжлийн хэлхээ” ТББ
- Хамрагдсан оюутны тоо: 22
- Оюутны тэтгэлгийн мөнгөн дүн: 153 сая төгрөг
- Төсөл хэрэгжих газар: Өмнөговь аймаг Ханбогд сум
- Төсөл хэрэгжих хугацаа: 2019 оны 06 дүгээр сар – 2021 оны 10 дүгээр сар.

Гурван талт зөвлөл нь Гэрээнд тохирсон ажлын хүрээнд Ханбогд сумын малчин өрхүүдэд хүртээмжтэй байдлаар нийтийн нөхөн олговор олгох үүднээс 2017 онд дотоодын их дээд сургуульд элсэн суралцаж буй малчин өрхийн оюутнуудад сургалтын тэтгэлэг олгох нэг удаагийн ажлыг хэрэгжүүлсэн. “Ханбогд хөгжлийн хэлхээ” орон нутгийн ТББ-тай хамтран хэрэгжүүлж буй энэхүү ажлын үр дүнд малчин өрхийн 22 оюутан хүүхдэд “Оюу толгой” компани 240 сая төгрөгийн оюутны сургалтын тэтгэлэг олгоно. Үүнээс 2020 оны байдлаар 153 гаруй сая төгрөгийн тэтгэлгийг олгоод байна. Тэтгэлэгт хамрагдсан 22 оюутнаас 12 оюутан их сургуулиа төгссөн. 10 оюутан сургуулиа хаясан. 12 төгсөгчдөөс ажлын байртай болсон 8, ажилгүй байгаа 4, Ханбогд сумын малчин өрхийн хүүхдүүдэд олгож буй оюутны тэтгэлэг мөнгөн дүнгээр:

| Он          | Оюутны тоо | Мөнгөн дүн         |
|-------------|------------|--------------------|
| 2017        | 20         | 51,329,985         |
| 2018        | 19         | 55,854,755         |
| 2019        | 12         | 30,942,500         |
| 2020        | 9          | 15,175,493         |
| <b>Нийт</b> | <b>-</b>   | <b>153,302,733</b> |





## ХАВСРАЛТ 1. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ 2017-2020

## МАЛЧДЫН ГОМДЛЫГ БАРАГДУУЛАХ 1,2-Р ГЭРЭЭНИЙ ЯВЦ

(6 дэд сэдвийн хүрээнд хэрэгжиж буй ажил 45 биелэлт дунджаар 57,8%, 100% хэрэгжсэн 20 ажил)

| №   | Гэрээний ажлууд   | Хариуцах тал | Шалгуур үзүүлэлт   | Гүйцэтгэлийн хувь 2020 3-р улирал | Гүйцэтгэл   |
|---|---|--------------|--|-----------------------------------|---|
| <b>ХЭРЭГГИЖ БУЙ БОЛОН ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТАНДАА БАЙГАА АЖЛУУД</b> |   |              |  |                                   |   |
| <b>БЭЛЧЭЭР 60%</b>  |   |              |  |                                   |   |
| 1   | Сумын нутаг дэвсгэр дэхь алдагдсан бэлчээрийн бүст тохируулга хийхийн тулд бэлчээрийн тогтолцоог дахин боловсруулах   | ОНЗЗ         | Төлөвлөгөө боловсруулсан байх                            | 40%                               | <p>Ойрын хугацаанд хэрэгжиж бгаа</p> <p>2010-2013 онд Монголын Бэлчээрийн менежментийн холбоо, 2014-2015 онд Нутаг Партнерс, 2018-2019 онд Вектор мэдээлэл байгууллага бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулж, мониторинг судалгааны тайлан өгсөн.</p> <p>Хүлээгдэж буй ажлууд:</p> <ul style="list-style-type: none"> <li>Иргэд, малчдын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх</li> <li>ХБ-д хийгдсэн судалгаанууд үндэслэн Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулах</li> <li>МАН 4 баг дээр хэлэлцүүлэг зохион байгуулах</li> <li>ИТХ-р хэлэлцүүлж, батлуулах</li> <li>ОТ санхүүжилтээр ХБ бэлчээрийн судалгаа хийсэн тайлангуудыг танилцуулж, мэдээлэл өгөх</li> <li>Мэдээлэл өгөх, танилцуулга материал бэлтгэх, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын зардлыг хариуцах</li> </ul> |
| 2   | Малчид уламжлалт байдлаар нүүдэллэх, ус бэлчээрийг чөлөөтэй хүртэх байдлыг дэмжиж, худаг, бэлчээрт малчид хориг тавьдгийг багасгах  | ОНЗЗ         | 237 гэрээ байгуулсан байх                                | 70%                               | <p>Ойрын хугацаанд хэрэгжиж бгаа</p> <p>Хүлээгдэж буй ажлууд:</p> <ul style="list-style-type: none"> <li>Зөвхөн гүн өрмийн болон инженерийн хийцтэй худгууд, нарны өргүүртэй худгуудад хийгдэнэ. Гар худагт хийхгүй. Бэлтгэл ажил, судалгаа хийгдсэн, Багийн дарга нарт хариуцуулаад гэрээ байгуулна.</li> </ul>  |
| 3   | Бэлчээрийн доорх усны нөөцийн судалгааны үр дүнд тулгуурлан худаг барих хөтөлбөрөөр дамжуулан шинэ бэлчээр нэмж бий болгох. Малчдын эзэмшлийн эрхийг тодорхой болгож, хэрэгжүүлэх | ОНЗЗ         | Усжуулагдах боломжтой бүх нөөц бэлчээр усжуулагдсан байх | 0%                                | <p>Ойрын хугацаанд хэрэгжих</p> <p>Хүлээгдэж буй ажлууд:</p> <ul style="list-style-type: none"> <li>Усжуулах шаардлагатай байгаа бэлчээрийн зураг, талбайн хэмжээ, хэрэгцээтэй байгаа уст цэгийн тооцоо хийх</li> <li>Отрын бүс буюу нөөц бэлчээрийг тодорхойлсон байх</li> <li>ХАА газар, БОАЖГ, Сав газрын захиргаагаас холбогдох зөвшөөрлийг авсан байх<br/>Уст цэг шинээр үүсгэх цэгийн нарийвчилсан байршлыг тогтоож өгнө<br/>худаг хүлээн авах акт, хариуцлагын болон эзэмшүүлэх гэрээ байгуулах</li> </ul>   |

|   |  |      |   |     |                               |   |
|---|--|------|---|-----|-------------------------------|---|
| 4 | <p>ОТ нь бэлчээрийн боломжийг түргэн нэмэгдүүлэхийн тулд дор дурдсан болон тэдгээрээр хязгаарлахгүйгээр аливаа эвдсэн/орхисон газруудаа (Хавсралт А) аль болох хурдан нөхөн сэргээх, эвдэгдсэн газраас тоос босох хугацааг богиносгох, хуучин буюу ашиглаж буй карьерууд дээр гарах ослын эрсдлийг бууруулах</p>   | ОТ   | <p>1) Биологийн нөхөн сэргээлт бүрэн хийгдсэн тухай Аймгийн Уул уурхайн ашиглалт, дэд бүтэц, бусад үйл ажиллагааны нөлөөгөөр эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг хүлээн авах ажлын хэсгийн акт<br/>2) одоо ашиглаж буй карьерууд дээр гарах ослын эрсдлийг бууруулах арга хэмжээ авсан байх (хашаа, тэмдэг тэмдэглэгээ гэх мэт)</p> | 70% | Ойрын хугацаанд хэрэгжиж бгаа | <p>Нийт 10 ажлын дундаж үзүүлэлтээр дүгнэв.</p> <p>Хийгдэж буй ажлууд:</p> <ul style="list-style-type: none"> <li>Манлайн замыг ашигладаг бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зөвшөөрөгдсөн зам, маршрутын дагуу журамлах (захирамж гаргах)</li> <li>нөхөн сэргээсэн талбайд зөвшөөрөлгүй машин явуулахгүй байхыг хариуцах</li> <li>Цагаан хад- Гасуун Сухайт хооронд ашигласан карьерийн үлдсэн 2т нь нөхөн сэргээлт</li> <li>Хуучин онгоц буудлын талбайн нөхөн сэргээлт</li> <li>Гүний хоолойн кэмпийн нөхөн сэргээлт</li> <li>Цагаан хад- Гасуун Сухайт хооронд ашигласан карьерийн үлдсэн 2т нь нөхөн сэргээлт</li> <li>Манлайн шороон замын хажуугийн салаа шороон замуудыг нөхөн сэргээх</li> </ul> |
| 5 | <p>Улсаас үндэсний шинжээчид томилж өгөх, сургалт явуулах зэргээр орон нутгийн захиргаанд дэмжлэг үзүүлэх, энэ арга хэмжээг хэрэгжүүлэхэд малчид, орон нутгийн байгууллагууд, бүх түвшний засаг захиргаа (баг, сум, аймаг, холбогдох мэргэжлийн байгууллагууд) санаачлагыг гартаа авч, бүгд хүчин чармайлт гаргах</p>  | ОНЗЗ | <p>Бэлчээрийн чиглэлээр 5 мэргэжилтэн сургалтанд хамрагдсан байх</p>  | 90% | Ойрын хугацаанд хэрэгжиж бгаа | <p>2014-2015 бэлчээр шинжилгээний чиглэлээр 5 мэргэжилтэн сургалтад хамрагдсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>Дахин 2 мэргэжилтэнийг сургах</li> </ul>   |
| 6 | <p>ГТЗ нь хамааралтай талуудыг татан оролцуулахад идэвхитэй оролцож малчдад холбогдох туслалцаа үзүүлэхэд ГТЗ-өөс гадуур идэвхитэй үүрэг гүйцэтгэх: Талууд одоо үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд, орон нутгийн иргэдийн болон засаг захиргааны бүтцийн газрууд (ж нь: багийн иргэдийн нийтийн хурал, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, мал аж ахуйн тасаг, газар ашиглалтын жилийн төлөвлөгөө боловсруулах үйл явц) зэрэг Сумын хөгжил цэцэглэлтэд чухал үүрэгтэй болохыг хүлээн зөвшөөрөх. Тухайлбал сумын засаг захиргаа малчдад газар, устай холбоотой маргаантай асуудлыг шийдвэрлэж ирсэн уламжлалт арга барилаа сэргээх эсвэл бэхжүүлэн хэрэглэх замаар ОТ-той хамааралгүй мал маллагаанд холбоотой асуудлаа хэрхэн шийдвэрлэж болох талаар бодолцоход туслаж дэмжих</p> | ОНЗЗ | <p>Засаг даргын захирамжийг малчид дагаж мөрдүүлэх арга хэмжээ авсан байх, БИН-ийн хурлаар захирамжийг сайтар танилцуулсан, захирамжид малчдыг хариуцлагатай болгох зүйл заалт оруулсан байх</p>  | 70% | төлөвлөлтийн шатанд байгаа    | <ul style="list-style-type: none"> <li>ЗД-ын захирамж жил бүр гарсан байх</li> <li>ЗД-ын захирамжийг малчдад мэдээллэх</li> </ul>   |



